



МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 7 сарын 18 өдөр

Дугаар 162

Улаанбаатар хот

Бүртгэлд хамруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэг, 57 дугаар зүйлийн 57.5 дахь хэсэг, Сангийн сайдын 2013 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 264 дугаар тушаалаар батлагдсан Бүртгэл хөтлөх журмын 4.4 дэх заалт, улсын ахлах байцаагчийн саналыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.1.4 дэх заалтыг зөрчсөн нэгдүгээр хавсралтад заасан нэр бүхий 14 хуулийн этгээдийг “Бүртгэл хөтлөх журам”-ын 4.5-д заасан хугацаагаар тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулсугай.

Хоёр. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавиж ажиллахыг Хууль, худалдан авах ажиллагааны бодлогын газар /Э.Хангай/, Төсвийн хяналт, эрсдлийн удирдлагын газар /Б.Батцэцэг/-т тус тус үүрэг болгосугай.

Гурав. Энэ тушаалын биелэлтийг хангаж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг Захиалагч нарт үүрэг болгосугай.

САЙД



Ч.УЛААН

ТЕНДЕРТ ОРОЛЦОХ ЭРХЭЭ ХЯЗГААРЛУУЛСАН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛД
 ХАМРУУЛАХ ЭТГЭЭДИЙН НЭРС

№	Гүйцэтгэгч компаний нэр	Гаргасан зөрчил	Зөрчил гаргасан огноо	Бүртгэлд хамруулах хугацаа дуусгавар болох огноо
1	Арвис интернэшнл ХХК	Гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй	2012.12.25	2015.12.25
2	Амарсанаа ХХК	Гэрээний үүргээ зөрчсөн	2013.11.30	2016.11.30
3	Баянхайрханы чоно ХХК	Мэргэжлийн үйл ажиллагаандаа алдаа гаргасан	2012.07.05	2015.07.05
4	Асати монгол ХХК	Гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй	2011.08.01	2014.08.01
5	Орчлон констракшн ХХК	Гэрээний үүргээ биелүүлээгүй	2012.06.01	2015.06.01
6	Назу ХХК	Мэргэжлийн үйл ажиллагаандаа алдаа гаргасан	2013.04.26	2016.04.16
7	Дөрвөн тэнхлэг ХХК	Гэрээний үүргээ биелүүлээгүй	2012.10.15	2015.10.15
8	Бэрх зараа ХХК	Гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй	2012.10.01	2015.10.01
9	Нийслэл өргөө ХХК	Гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй	2013.12.10	2016.12.10
10	Мэдрүүр ХХК	Гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй	2012.09.15	2015.09.15
11	Клэстон балансир ХХК	Гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй	2012.10.20	2015.10.20
12	Монгол эксковатор ХХК	Гэрээний үүргээ биелүүлээгүй	2012.10.26	2015.10.26
13	Мишээл-Од ХХК	Гэрээний үүргээ биелүүлээгүй	2012.10.10	2015.10.10
14	Апгрейд ХХК	Гэрээний үүргээ биелүүлээгүй	2013.01.13	2016.01.13

* Сангийн сайдын 2013 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 264 дугаар тушаалаар батлагдсан "Бүртгэл хөтлөх журам"-ын 4.5-д тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийг тухайн зөрчлийг гаргаснаас хойш 3 жилийн хугацаанд Засгийн газрын худалдан авах ажиллагаанд аливаа нэг хэлбэрээр оролцохыг хориглоно гэж заасан.